



**МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН
ТУШААЛ**

2017 оны 09 сарын 01 өдөр

Дугаар А/127

Улаанбаатар хот

Хяналт шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх
арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны “Хөдөлмөр эрхлэхэд зуучлах тусгай зөвшөөрөлтэй байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт, үнэлгээ хийх тухай” А/47 дугаар тушаалаар томилогдсон ажлын хэсгийн хөдөлмөр эрхлэхэд зуучлах тусгай зөвшөөрөлтэй байгууллагуудын үйл ажиллагаанд хийсэн хяналт, шалгалтын дүнг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хяналт, шалгалтын дүнг үндэслэн нэгдүгээр хавсралтад нэр дурдагдсан “хангалтгүй” буюу 50.0 хувиас доош үнэлгээ авсан байгууллагуудын Монгол Улсын иргэдийг гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучлах тусгай зөвшөөрлийг 2017 оны 09 дүгээр сарын 04-ний өдрөөс 2017 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр хүртэл хугацаагаар түдгэлзүүлсүгэй.

2. Хяналт, шалгалтын мөрөөр дараах арга хэмжээг авч ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Ц.Мөнхзул/-т үүрэг болгосугай.

2.1. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тухай мэдэгдлийг холбогдох байгууллагуудад нь хүргүүлэх,


2.2. Уг шалгалтаар 58.3-75.0 хувьтай үнэлэгдсэн 32 байгууллагаас Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн хугацаатай албан шаардлагын дагуу авсан арга хэмжээний талаар мэдээллийг авч, 2017 оны 10 дугаар сарын 25-ны дотор танилцуулах,

2.3. Хяналт шалгалтын явцад иргэдээс их хэмжээний төлбөр, хураамж авсан боловч зуучлах үйлчилгээ үзүүлээгүй, гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй үйл ажиллагаа явуулсан байж болзошгүй үйл ажиллагааг зохих хууль хяналтын байгууллагад шилжүүлж, шалгуулах.

3. Цаашид тухайн жилд дадлагажигч илгээсэн байх нөхцлийг үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сунгахад гол шалгуур болгон ажиллахыг Хөдөлмөр, эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Ц.Амартөгс/-т даалгасугай.

4. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Г.Өнөрбаяр/-д үүрэг болгосугай.

САЙД



Н.НОМТОЙБАЯР

МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙГ ГАДААДАД ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХЭД ЗУУЧЛАХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ НЬ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ
БАЙГУУЛЛАГУУДЫН НЭР

1. Аск Эба ХХК
2. Баян алтан бухт ХХК
3. Би Жи Сервис ХХК
4. Биллихиро ХХК
5. Бюула ХХК
6. Жи Пи Партнерс ХХК
7. Кайкакү ХХК
8. Монжа Интернешнл Эдүкейшн ХХК
9. Нарт Атас ХХК
10. Монфүжи ХХК
11. Монгол стандарт ХХК
12. Сарухай ХХК
13. Си Эс Эм Эм ХХК
14. Трансформер ХХК
15. Ти Ай Партнерс ХХК
16. Тоба маркет ХХК
17. Хар- Од ХХК
18. Эрмэг жигүүр ХХК
19. Эрхэс Очир Эрдэнэ ХХК